

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
(2024 оны III улирлын байдлаар)

2024 оны 09 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

№	ХБТББ-т тусгагдсан зорилт	Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ	Суурь Түвшин (2022 он)	Зорилтот түвшин, үр дүн			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн Хувь
								Зорилтот түвшин, үр дүн	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ												
Салбарын үр дүн: Нийслэлээс зохион байгуулж буй олон улсын шинж чанартай томоохон арга хэмжээнд 70,000 жуулчныг хамруулна.												
152	НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.1.1	Аялал жуулчлалын мэдээлэл сурталчилгааны төвийг 1-ээр нэмэгдүүлж үйл ажиллагааг үргэлжлүүлэх	2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	300.0	6	1	100.0	98.0	Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг 7 байршилд ажиллуулж байна. Үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг шинээр жанжин Д.Сүхбаатарын талбайд байгуулах төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажлыг гүйцэтгүүлж үйл ажиллагааг эхлүүлсэн.	100
153	НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.1.2	Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр нийтийг хамарсан олон улсын шинж чанартай томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулах	2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	1,175.0	12 арга хэмжээ, 50,000 жуулчин	15 арга хэмжээ, 70,000 жуулчин	890.7	866.7	"Монголд зочлох жил"-ийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан	90

											гадаад, дотоодын жуулчдыг татах, урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны III улирлын байдлаар төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Мазаалай” олон улсын цас мөсний наадам, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Франц соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээ, “Талын салхи” олон улсын мото наадам, “Плэйтийм” олон улсын хөгжмийн наадам, “Дээлтэй Монгол наадам” “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Улаанбаатар фүүд фестиваль”, “Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль”, “Японы соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээ, “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг зэрэг нийт 14 арга хэмжээг зохион байгуулж 350,050 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчид үзэж сонирхсон.	
154		"Нэг жуулчин-нэг мод" жуулчны төгөлийн тохижилтын ажлыг үргэлжлүүлэх	2024	НАЖГ	Хандив, тусламж	/-/	100	100	15.8	15.8	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд гадаад, дотоодын аялагч, жуулчид мод тарих боломжийг бүрдүүлэх, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд “Жуулчин төгөл”-	70

											ийг 2022 онд бий болгож 18 төрлийн 510 мод тарих ажлыг зохион байгуулсан. "Ногоон хот-Иргэний оролцоо" 2024 оны хаврын мод тарих арга хэмжээний хүрээнд тарьсан модны арчилгаа, цэнэг усалгаа нөхөн тарилтыг хийх, шинээр мод тарих ажлыг 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж 180 мод, Дэлхийн аялал жуулчлалын өдөр, Монгол Улсад аялал жуулчлалын салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд салбарын 80 гаруй байгууллагатай хамтран 10 төрлийн 381 мод тарих ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.	
155		Улаанбаатар хотын тойрон аяллын "Сити тур" төслийг үргэлжлүүлэх	2024	НАЖГ	-	/-/	100	100	-	-	"Сити тур" төслийн хүрээнд жуулчдад зориулсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, хотын аяллыг хөгжүүлэх зорилгоор Улаанбаатар хот болон хот орчмын түүх, соёлын дурсгалт газрууд, ахуй амьдрал, ёс заншил, байгальтай танилцах болон үзвэр, худалдаа үйлчилгээг хамруулсан 4 төрлийн аяллын маршрутаар 35 удаагийн хотын аялалд 1198 хүнийг хамруулж нийслэлийн төсөвт 25,800,000 (хорин таван сая найман зуун мянга) төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.	90

156		Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх замаар аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах	2024	НАЖГ	-	/-/	4	11	-	-	Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, гадаад дотоодын иргэд, жуулчдын идэвхтэй аялал, амралтыг дэмжих зорилгоор www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд “Өвлийн улирлын хямдрал” цэсийг үүсгэж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 9 салбарын 62 аж ахуйн нэгж, байгууллага 500 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 10-50 хувь хүртэл хөнгөлөлттэй үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүлэв.	100
157	НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.1.3	Жуулчдын зорин очих аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх	2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	120.0	1	1	144.8	45.2	Улаанбаатар хот, хот орчмын эко аялал жуулчлалын бүтээгдэхүүний маршрутын тоог нэмэгдүүлэх, түүх, соёлын дурсгалт газруудыг олон нийтэд таниулах, дотоодын аялагчдыг зөв зохистой аялах танин мэдэхүйг дээшлүүлэх зорилгоор “Хүрээлэн” төсөлтэй хамтран “Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим катологи бий болгох төслийг эхлүүлсэн. Төслийн хүрээнд жуулчдын зорин очих аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор эко аялал, гэрэл зургийн аялал, хөхтөн амьтан ажиглах аялал, шувуу ажиглах аялал, цэцгийн аялал, ханан хаданд авирах	70

											аялал, түүх соёлын аялал зэрэг 20 гаруй аяллын бүтээгдэхүүнийг багтаан ажлыг гүйцэтгэж байна.	
158	НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.2.1	Улаанбаатар хотын танилцуулга сэтгүүл, цахим сэтгүүл, газрын зураг, хөтөч ном, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх контент зэргийг шинэчлэх	2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	90.0	13,000	2,000	90.9	90.6	Улаанбаатар сэтгүүлийг 6 орны хэлээр (Англи, Япон, Солонгос, Герман, Орос, Хятад) 11,000 ширхэг, Улаанбаатар хөтөч ном 2,000 ширхэг, жуулчдад зориулсан Улаанбаатар хотын газрын зураг "City map" 5,000 ширхэг нийт 18,000 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлж Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд болон гадаад, дотоодод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн, уулзалт, хурал, эвент арга хэмжээнүүдэд тарааж Улаанбаатар хотыг сурталчлан ажиллаж байна. Мөн "Улаанбаатар өвлийн наадам", "Бүргэдийн баяр", "Тэнгэр" олон улсын бөөгийн фестиваль, "Талын салхи" олон улсын мото фестиваль "Дээлтэй монгол" наадам, "Даншиг наадам-Хүрээ цам" шашин соёлын наадам, "Улаанбаатар фүүд фестиваль" зэрэг арга хэмжээнүүдтэй холбоотой 42 контент хийж 2,734,679 хүнд хүргэсэн.	100

159		Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, арга хэмжээг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулан сурталчлах	2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	50.0	1,000,000	1,000,000	-	-	Аялал жуулчлалын салбар болон байгууллагын үйл ажиллагаа, Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, арга хэмжээтэй холбоотой нийт 1307 мэдээ мэдээллийг байгууллагын www.tourism.ub.gov.mn , www.visitulaanbaatar.net цахим хуудас, Instagram, facebook хуудас болон хэвлэл мэдээллийн 20 сайт, 10 телевиз, 2 радиогоор түгээн 1,659,489 хүнд хүргэж, үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлан ажилласан.	100
160		Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг Эй Ар, Ви Ар /AR, VR/ технологиор хийж гадаад улс оронд сурталчлах	2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	350.0	-	2	-	-	Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг дээр суурилсан AR, VR технологиор хийх судалгааны ажлыг зохион байгуулсан. Санхүүжилтээс шалтгаан уг ажил хийгдээгүй болно.	30
161		Жуулчдад зориулсан гар утасны аппликейшн хөгжүүлэх	2024	НАЖГ	-	/-/	-	1	-	-	Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг хэрэгцээт мэдээлэл, үйлчилгээгээр хангах, хотын аялалд хамруулах зорилгоор “UB City pass” жуулчдад зориулсан мэдээ мэдээлэл, бүтээгдэхүүн үйлчилгээний гар утасны аппликейшн болон вэб сайтад суурилан бүтээгдэхүүн, үйлчилгээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс нэвтрүүлэн 3 төрлийн аяллын	100

											бүтээгдэхүүнийг гаргаж 270 жуулчинд үйлчилгээ үзүүлсэн.	
162	НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.2.1	"Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбоо"-ны дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулах	2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	20.0	-	100	-	-	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санаачилгаар Зүүн хойд Азийн хотуудын өмнө тулгарч байгаа асуудлуудыг хэлэлцэж харилцан туршлага солилцох, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор VI дахь удаагийн Зүүн хойд Азийн хотын дарга нарын чуулга уулзалт олон улсын арга хэмжээг “Зүүн хойд Азийн хотуудын тогтвортой хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийг (ТХХТ) дэмжин хэрэгжүүлэх нь” сэдвийн хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдав. Зургаа дахь удаагаа зохион байгуулагдсан энэхүү чуулга уулзалт нь 2 хэсгийн хүрээнд буюу “Тогтвортой дэд бүтэц, тээвэр, сэргээгдэх эрчим хүч, хог хаягдлын менежмент, дахин боловсруулалтын чиглэлээр төр, хувийн түншлэлийг дэмжин ажиллах нь”, “Эдийн засгийн өсөлтөд аялал жуулчлал, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжин ажиллах нь” сэдвийн дор зохион байгуулагдаж “Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбоо”-ны	100

											гишүүн хотуудын дарга нарын төлөөлөл оролцлоо.	
163		Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор олон улсын арга хэмжээнд оролцох, зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх	2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	400.0	6	2	51.5	51.5	“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор холбогдох яамдууд, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, тур оператор компаниудтай хамтран олон улсын 3 үзэсгэлэнд оролцсон. Үүнд: 1.ХБНГУ-ын Берлин хотноо 2024 оны 03 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 58 дахь удаагийн “ITB Berlin 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, 2.БНСУ-ын Сөүл хотод 2024 оны 05 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 39 дахь удаагийн “SEOUL INTERNATIOL TRAVEL FAIR- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцон “GO MONGOLIA” аялал жуулчлалын брэндингээ сурталчлан танилцуулж “Шилдэг PR маркетингтай Booth”-ээр шалгарсан. 3. Япон улсын Токио хотноо 2024 оны 09 сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж буй “Travel Expo Japan-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцон Улаанбаатар хотыг сурталчлан ажиллаж байна.	100

164			2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	100.0	-	1	100.7	100.7	<p>Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор 2 арга хэмжээг хамтран зохион байгууллаа. Үүнд:</p> <p>1.Монгол Улсаас БНХАУ суугаа Элчин сайдын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, “Хүннү Айр” хамтран “GO MONGOLIA” ROAD SHOW-2024 арга хэмжээг БНХАУ-ын Гуан-жао, Хонгконг, Бээжин зэрэг 3 хотод 2024 оны 04 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд зохион байгуулж, арга хэмжээний үеэр 2024 онд Монгол Улс, Улаанбаатар хотод зохион байгуулагдах олон улс болон үндэсний хэмжээний чанартай эвент арга хэмжээний нэгдсэн танилцуулгыг оролцогчдод хүргэж, арга хэмжээнд Монгол Улсын 21, БНХАУ-ын 175 аялал жуулчлалын тур оператор компаниуд оролцлоо.</p> <p>2."Улаанбаатар травел экспо-2024" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран 2024 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд 10 дахь жилдээ Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулж, үзэсгэлэнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Аялал</p>	100
-----	--	--	------	------	--------------------------	-------	---	---	-------	-------	---	-----

											жуулчлалын танхим, БНСУ-ын “Korea Tourism Organization”-ын 17, Монгол Улсаас Өмнөговь, Дархан, Ховд, Завхан, Увс зэрэг 5 аймаг болон нийт 87 байгууллага, аялал жуулчлалын тур оператор компани, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид аяллын дагалдах хэрэгсэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаагаа танилцуулан оролцлоо.	
165		Найрамдалт харилцаат хотуудын аялал жуулчлал, соёл урлагийн өдрүүдийг Улаанбаатар хотод зохион байгуулах	2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	120.0	3	3	90.2	90.2	Улаанбаатар хоттой найрамдалт харилцаат улс, хотуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Францын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулж 3000 гаруй хүн, “Япон соёл, аялал жуулчлалын өдөрлөг” (Japan festival) арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 24,25-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж 12,000 гаруй хүн, “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” (Korea Week) арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 30-31, 09 дүгээр сарын 01-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, 33,000 гаруй хүн үзэж сонирхсон. “Соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээнүүдийг тохиолдуулан БНФУ-аас	100

											112, Япон улсаас 168, БНСУ-аас 198 нийт 478 зочид төлөөлөгчид зорин ирж оролцон улсынхаа үндэсний соёл урлаг, спорт болон боловсрол, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаар олон нийтэд танилцуулав.	
166	НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.3.1	Оюутан хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх цагдаа	2024	НАЖГ	Нийслэл-ийн төсөв ГХУСАЗ СЗ-ийн зардал	450.0	150	150	160.0	160.0	Жуулчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, оюутан залуусыг түр ажлын байраар хангаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Аялал Жуулчлалын газар, Монголын Оюутны холбоо хамтран “Оюутан цагдаа-2024” арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс 08 дугаар сарын 13-ны өдрийн хооронд 2 сарын хугацаанд хэрэгжүүлж, Улаанбаатар хотын 14 их, дээд сургуулийн 50 оюутан ажиллалаа. Оюутан цагдаа нар ажиллах хугацаандаа Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт гэмт хэргийн 13, зөрчлийн шинжтэй 3213 дуудлага мэдээлэл өгч, дотоодын 16,178 иргэнд туслалцаа үзүүлэн, гадаадын 17,255 иргэнд хэлмэрчилж, 5 төрлийн 20,500 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тараан, 2600	90

											хүүхдэд эцэг эхийн утасны дугаар бүхий бугуйвч зүүж, эцэг эх, асран хамгаалагчаасаа төөрсөн 136 бага насны хүүхдийг ар гэрт нь, 5 хүүхдийг Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, Монгол орны байгалийн дурсгалт болон түүх соёлын дурсгалт газар, үзвэр үйлчилгээний талаар 5 бүлэг 58 мэдээ, мэдээлэл бүхий QR кодыг гадаадын 16,981 жуулчдад танилцуулан ажилласан.	
167	НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.3.2	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад тавигдах ерөнхий шаардлагад нэмэлт оруулах замаар и-баримтад бүрэн холбож, нийслэл хотын албан татвараас төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх	2024	НАЖГ	-	11,128.0	10,000.0	-	-	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-ын хүрээнд “Онлайн бизнес төв” нэгдсэн системд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудын бүртгэлийг нэмэгдүүлж, 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Нийслэл хотын албан татварт 18,170,078.8 төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.	100	
168		"Зочид буудал, дэн буудал, амралтын газар тавигдах ерөнхий шаардлага (MNS 4588:2008, MNS 6043:2019, MNS 6043:2019) стандартын үзлэг зохион байгуулах	2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	20.0	556	44	-	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/146 дугаар захирамжаар байгуулагдсан Богдхан Уулын тусгай хамгаалалтай газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын нийслэл хотын татвар, бүртгэл мэдээллийг баталгаажуулах,	50	


											дэлгэрэнгүй мэдээлэл, судалгаагаар хангах хамтран ажиллах үүрэг бүхий Ажлын хэсэг 2024 оны 05 дугаар сарын 06-10-өдрүүдэд дээрх байршлуудад ажилласан. Үйл ажиллагаатай уялдуулан үндэсний болон хотын стандартуудыг сурталчлан таниулах, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 19 амралтын газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгууллаа.	
169	НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.3.3	Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр олон улсын туршлагыг судлах, экспертийг урьж төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулах	2024	НАЖГ	Нийслэл -ийн төсөв	30.0	450	450	264.1	264.1	Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын удирдлага, ажилтнууд, жуулчны хөтөч-тайлбарлагчдын ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор дотоодын болон улсын туршлагыг судлах, экспертүүдийн 6 төрлийн 17 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 412 хүнийг хамруулав. Үүнд: 1. Аялал жуулчлал өндөр хөгжсөн улсуудад туршлага судлуулах, тогооч нарын ур чадварыг дээшлүүлэх Олон үндэсний хоолны тогооч бэлтгэх “Гастро аялал-2024” сургалтын хөтөлбөрийн хүрээнд БНСУ, БН Узбекистан улс, ОХУ, Турк, Хонг Конг, Япон, Тайланд зэрэг улсуудад туршлага судлах 7-10 хоногийн сургалтыг 2024	90

											<p>оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулж 56 хүн,</p> <p>2.Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 22-ны хооронд зохион байгуулж 56 хөтөч,</p> <p>3. Чингис хаан Үндэсний музейд тайлбар хийх эрх олгох” сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 15,16 болон 29,30-ны өдрүүдэд зохион байгуулж 90 хүн,</p> <p>4.“Олон улсын эксперт багштай зочлох үйлчилгээний сургалт”-ыг 2024 оны 05 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд зохион байгуулж 163 хүн,</p> <p>5.“Гастро аялал-2024” сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2 дугаар шатны дотоодын сургалтыг 2024 оны 5 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтыг Тайланд болон Хятад (Зүүн Өмнөд Ази) хоол, Узбек болон Турк үндэстний хоол, Солонгос болон Интернэшнл хоолны чиглэлээр зохион байгуулж 250 хүн,</p> <p>6.“Оюутан цагдаа-2024” арга хэмжээнд ажиллах оюутнуудын сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж 50 оюутан цагдаа хамрагдлаа.</p>	
170	НХТЖҮЧ-4.3.1	Найрсаг Улаанбаатар арга хэмжээг	2024	НАЖГ	-	/-/	90	90	-	-	Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар-2”	70

НЗДҮАХ- 3.4.4.1	үргэлжлүүлэн хэрэгжүүлэх										арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 7 зорилтын 77 арга хэмжээний биелэлт 2024 оны III улирлын байдлаар 70 хувийн хэрэгжилттэй байна.
Нийт дундаж 87.0 хувь											

ТАНИЛЦСАН:

ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

Д.ГАНБОЛД

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ

МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИК СУДАЛГАА,

ДҮН ШИНЖИЛГЭЭ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

Ч.ЭНХ-ОТГОН